**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 08 өдөр Дугаар А/274 Чингис хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "б", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Төлөвлөгөө батлах тухай" А/595, "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Тогтвортой хөгжлийн боловсрол II" төслийг хэрэгжүүлэхэд зориулж Хан Хэнтий цогцолбор сургууль, Тэмүүжин Цогцолбор сургууль, Галшар, Баян-Адарга, Дадал сумын Ерөнхий боловсролын сургуулиудад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дэмжлэгт шаардагдах 37,500,000 (гучин долоон сая, таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Г.Лхагвахатан)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ

231011526

Аймгийн Засаг даргын 2021 оны
06 дугаар сарын 08 өдрийн A/274
дугаар захирамжийн хавсралт

Зардлын төсөө

| Д/д | Зардлын нэр | Нийт үнэ |
|---|---|---|
| 1 | Хан Хэнтий цогцолбор сургууль | 7500,000 |
| 2 | Тэмүүжин цогцолбор сургууль, | 7500,000 |
| 3 | Галшар сумын Ерөнхий боловсролын сургууль | 7500,000 |
| 4 | Баян-Адарга сумын Ерөнхий боловсролын сургууль | 7500,000 |
| 5 | Дадал сумын Ерөнхий боловсролын сургууль | 7500,000 |
| | **Нийт** | **37,500,000** |